



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/110

Баянхутаг сум

**Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд
тодотгол хийх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.4, 32.1.11, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтонд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголыг хавсралтаар баталсугай.

2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулахыг сумын Засаг даргын орлогч /М.Мөнхнаран/, Засаг даргын тамгын газрын дарга /БЗолбоо/ нарт үүрэг болгосугай.

3. Тодотгол хийхтэй холбоотой мэдээ судалгааг үнэн зөв гарган тодотголд тусгуулахыг баг, албан байгууллагын удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдэд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ

Хянан: Засаг дарга
Боловруулсан: ЗДТГ-ийн дарга
Хүрэг: 5